МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛОН УЛСЫН ХУРАЛД СУУДАЛТАЙ 5 НАМ, ЭВСЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН БАЙР СУУРИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА”-НЫ ТАЙЛАН

Судалгааны төрөл: **Фокус бүлгийн ярилцлага**
Судалгааны код: **СТ-25/904**
Огноо: 2025 он 12 сар 17 өдөр

Хянасан: ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр (PhD)

Судалгаа удирдсан: Парламентын хөгжлийн хэлтсийн дарга П.Түмэнцэцэг

Судлаач: Парламентын хөгжлийн хэлтсийн судлаач А.Эрхэс

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

АГУУЛГЫН ТОВЬЁГ i
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ iii
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ iii
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ 1
БҮЛЭГ НЭГ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 4
1.1. 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүн 4
1.2. УИХ болон УИХ-д суудал бүхий улс төрийн намуудын талаарх байр суурь 12
1.3. Засгийн газрын үйл ажиллагаа 23
БҮЛЭГ ХОЁР. УИХ-Д СУУДАЛ БҮХИЙ 5 НАМ, ЭВСЛИЙН ДАРГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ХҮЛЭЭЖ БУЙ ХҮЛЭЭЛТ 30
БҮЛЭГ ГУРАВ. 2027 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТААМАГЛАЛ 34
СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН 38
НОМ ЗҮЙ 41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан Нам
БНН	Бүгд Найрамдах Нам
ДЦС	Дулааны Цахилгаан Станц
ЗГ	Засгийн Газар
ИЗНН	Иргэний Зориг Ногоон Нам
МАН	Монгол Ардын Нам
МУ	Монгол Улс
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ПСХХ	Парламентын Судалгаа, Хөгжлийн Хүрээлэн
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УИХ	Улсын Их Хурал
ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮН	ХҮН нам
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
ЧД	Чингэлтэй дүүрэг
ҮЭ	Үндэсний Эвсэл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүвэр 2
Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын нас хүйсийн харьцаа 2
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй салбар 3
Хүснэгт 4. УИХ-д суудал бүхий МАН, АН, Хүн нам, Үндэсний эвсэл, ИЗНН-уудаас иргэдийн хүлээлт 21
Хүснэгт 5. УИХ-д суудал бүхий 5 нам, эвслийн дарга нараас иргэдийн хүлээж буй хүлээлтүүд 33

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ иргэдийн хүлээлтэд нийцэж байгаа эсэх 4
График 2. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ хүлээлтэд нийцэж байгаа шалтгаан 5
График 3. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ хүлээлтэд нийцэхгүй байгаа шалтгаан 7
График 4. 2024 оны сонгуулиар МАН олонх болж, ялалт байгуулсан шалтгаан 8
График 5. 2024 оны УИХ сонгуулийн АН-ын үр дүнд хандах олон нийтийн хандлага 9
График 6. 2024 оны сонгуулиар АН сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авсан шалтгаан 10
График 7. 2024 оны сонгуулиар АН олонх болоогүй шалтгаан 11
График 8. Хүн нам УИХ-д 8 суудал авч, өмнөх сонгуулиудтай харьцуулахад гишүүдийн тоогоо нэмж чадсан шалтгаан 12
График 9. 2024 оны сонгуулиар бүрдсэн 126 гишүүнтэй парламент өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулсан үр дүн 12
График 10. 126 гишүүнтэй УИХ-ыг өмнөх 76 гишүүнтэй УИХ-тай харьцуулсан сөрөг талууд 13
График 11. 126 гишүүнтэй УИХ-ыг өмнөх 76 гишүүнтэй УИХ-тай харьцуулсан эерэг талууд 14
График 12. УИХ-д суудал бүхий 5 нам, эвсэл (МАН, АН, Хүн нам, Үндэсний эвсэл, ИЗНН) дундаж үнэлгээ 14
График 13. УИХ-д суудал бүхий 5 нам, эвслийн (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) үнэлгээний үндэслэл 15
График 14. Монгол Ардын намын үнэлгээний үндэслэл 16
График 15. Ардчилсан намын үнэлгээний үндэслэл 17
График 16. ХҮН намыг үнэлсэн үнэлгээний үндэслэл 18
График 17. Үндэсний эвслийн хэрхэн ажиллаж буйд иргэдийн өгсөн үнэлгээ 18
График 18. Иргэний Зориг Ногоон Намын хэрхэн ажиллаж буйд иргэдийн өгсөн үнэлгээ 19
График 19. УИХ-д суудал бүхий намуудаас иргэд хүлээлттэй байгаа эсэх үр дүн 19
График 20. УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах тал дээр иргэдийн санал 22
График 21. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар өнгөрсөн хугацаанд хэр зэрэг ажилласан гэж үзэж буй иргэдийн үнэлгээ 23
График 22. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг сайн ажилласан гэж дүгнэсэн шалтгаан 24
График 23. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг хангалтгүй ажилласан гэж дүгнэсэн шалтгаан 25

График 24. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ....25
График 25. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар сайн ажиллаж байна гэж дүгнэсэн шалтгаан....26
График 26. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар хангалтгүй ажиллаж байна гэж дүгнэсэн шалтгаан....27
График 27. Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас хүлээлттэй байгаа эсэх....27
График 28. Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас хүлээх хүлээлт....29
График 29. МАН дараагийн даргад тохирох хүн....30
График 30. Дараагийн МАН-ын даргад Г.Занданшатар тохирно гэж үзсэн шалтгаан....30
График 31. Дараагийн МАН-ын даргад Д.Амарбаясгалан тохирно гэж үзсэн шалтгаан....31
График 32. МАН-ын намын даргын сунгаанд Ерөнхий сайд Г.Занданшатар, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нарын хэнийг нь ч дэмжээгүй шалтгаан....31
График 33. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон намаас хэн хэн нэр дэвшинэ гэж бодож байгаа талаарх таамаглал /Давтамжаар/....35
График 34. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялалт байгуулж чадах эсэхэд иргэдийн таамаглал....35
График 35. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялна гэж таамагласан үндэслэл....36
График 36. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялагдах үндэслэл....37
График 37. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аль намаас нэр дэвшигч ялалт байгуулна гэж бодож байгаа талаарх үр дүн....37

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

2024 оны УИХ-ын сонгууль бүсчилсэн хэлбэрээр, холимог сонгуулийн тогтолцоогоор явагдаж, 126 гишүүнтэй парламент бүрдэж ажиллаад нэг жил гаруй хугацаа өнгөрч байгаа энэ үед УИХ болон УИХ-д суудал бүхий улс төрийн намуудын үйл ажиллагаа дахь иргэдийн сэтгэл ханамж, хүлээлтийг тодорхойлох зайлшгүй шаардлага үүсээд байна.

УИХ-ын үйл ажиллагаа болон улс төрийн намуудын талаарх асуудлыг тодруулах хүрээнд Засгийн газар, УИХ-д суудал бүхий улс төрийн намын дарга, үйл ажиллагаа, 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх асуудлыг орхигдуулах боломжгүй юм.

Сонгуулийн үр дүнд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Хамтарсан Засгийн газар бүрдэж ажилласан ч 2025.6.03-ны өдөр огцорч, 2025.6.13-ны өдөр Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайдаар Г.Занданшатарыг томилсон. Шинэ Засгийн газар бүрэлдэн үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш 100 орчим хоног байна.

Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хуралд суудалтай 5 нам, эвслийн талаарх олон нийтийн байр суурийг тодорхойлох хэрэгцээ шаардлагыг үндэслэн Парламентын Судалгаа, Хөгжлийн хүрээлэнгийн захиалгаар Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 22-ноос 31 өдрийн хооронд хийсэн[1].

Судалгааны зорилго: Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хуралд суудалтай 5 нам, эвслийн талаарх олон нийтийн байр суурийг тодорхойлох.

Судлах зүйл: УИХ, Засгийн газар, УИХ-д суудал бүхий улс төрийн нам, Ерөнхийлөгчийн сонгууль

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны тайлан үндсэн гурван хэсэгтэй байна. Үүнд:

1. Улсын Их Хурал, Засгийн Газрын үйл ажиллагаа
2. Улс төрийн намуудын удирдлага зохион байгуулалт
3. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн таамаглал

Судалгааны арга: Фокус бүлгийн ярилцлага

Судалгаанд нийт 124 оролцогч хамрагдсан бөгөөд хүйсийн харьцааг тэнцвэртэй, 5 насны ангиллаар төлөөлөл бүрдүүлсэн. Чанарын судалгаанд түүврийн хэмжээ нь статистик төлөөлөлд бус, харин туршлага, тайлбар, шалтгааны олон талт байдлыг илрүүлэхэд чиглэдэг гэж үздэг (Morgan, 1997).

Өгөгдлийг Улаанбаатар хотын 4 дүүрэг (СХД, СБД, ХУД, ЧД) болон 4 аймаг (Хөвсгөл, Ховд, Дорнод, Өвөрхангай)-аас цуглуулсан ба аймаг бүрийн аймгийн төв болон нэг сумыг хамруулснаар хот, орон нутгийн хөдөөгийн ялгаатай нөхцлийг харьцуулах газарзүйн сегментчилэл нь улс төрийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгаанд онцгой ач холбогдолтой болохыг өмнөх судалгаанууд онцолдог (Kitzinger, 1995).

Фокус бүлгийн судалгааг нийт 12 удаагийн хэлэлцүүлгээр зохион байгуулж, нэг бүлэгт дунджаар 10 оролцогч хамруулсан. Фокус бүлгийн нэгжийн хэмжээ 6–10 хүн байх нь арга зүйн хувьд нийтлэг бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн хүрээ гэж судлаачид үздэг (Morgan, 1997).

[1] Тус мэдээлэл цуглуулалт нь МАН-ын даргад УИХ-ын дарга Д.Амарбаясгалан, Ерөнхий сайд Г.Занданшатар нар өрсөлдөж буй хугацаатай давхардсан болно.

Судалгааны үр дүнг боловсруулахдаа зарим эрэмбэлсэн тоон утгуудад тайлбарлах анализын шинжилгээ хийсэн ба дийлэнх хэсэгт давтамжийн шинжилгээ ашигласан.

Түлхүүр үг: *Улсын Их Хурал, Улс төрийн намууд, Сонгуулийн үр дүн, Иргэд олон нийтийн хандлага, Ерөнхийлөгчийн сонгууль*

Key words: *State Great Hural, Political Parties, Election Results, Public Attitudes of Citizens, Presidential Election*

Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Фокус бүлгийн ярилцлагын судалгаанд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүргээс нийт 44, Дорнод аймгийн төв болон Булган сумаас нийт 20, Хөвсгөл аймгийн төв болон Их-уул сумаас нийт 20, Өвөрхангай аймгийн төв болон Нарийнтээл сумаас нийт 20, Ховд аймгийн төв болон Буянт сумаас нийт 20 хүн оролцсон байна.

Хүснэгт 1. Түүвэр

Хот/Аймаг	Дүүрэг/Сум	Тоо	Хувь
Улаанбаатар хот	Сонгинохайрхан дүүрэг	11	9%
	Сүхбаатар дүүрэг	11	9%
	Хан-Уул дүүрэг	11	9%
	Чингэлтэй дүүрэг	11	9%
Дорнод аймаг	Чойбалсан сум	10	8%
	Булган сум	10	8%
Хөвсгөл аймаг	Мөрөн сум	10	8%
	Их-уул сум	10	8%
Өвөрхангай аймаг	Арвайхээр сум	10	8%
	Нарийнтээл сум	10	8%
Ховд	Ховд сум	10	8%
	Буянт сумаас	10	8%
Нийт		**124**	**100%**

Судалгаанд 18-аас 79 насны нийт 124 хүн оролцсон бөгөөд дундаж нас нь 37.3 байна. Хүйсийн харьцаа тэнцвэртэй буюу 62 эрэгтэй (50%), 62 эмэгтэй (50%) оролцсон байна.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын нас хүйсийн харьцаа

Насны бүлэг	Тоо	Хувь	Хүйс	Тоо	Хувь
18-24 нас	28	23%	Эрэгтэй	62	50%
25-29 нас	24	19%	Эмэгтэй	62	50%
30-39 нас	24	19%	**Нийт**	**124**	**100%**
40-49 нас	24	19%			
50-аас дээш нас	24	19%			
Нийт	**124**	**100%**			

Судалгаад оролцогчдын 40% нь төрийн албанд ажилладаг, 14% нь хувийн хэвшилд ажилладаг, 11% нь оюутан сурагч, 9% нь тэтгэвэр, группт байдаг, 3% нь ажил эрхэлдэггүй, 2% нь гэрийн эзэгтэй, 2% нь иргэний нийгмийн байгууллагад ажилладаг, 1% нь малчин байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй салбар

Ажилладаг салбар	Тоо	Хувь
Төрийн алба	50	40%
Хувийн хэвшил	17	14%
Оюутан, сурагч	14	11%
Иргэний нийгмийн байгууллага	2	2%
Тэтгэвэр, групп	11	9%
Гэрийн эзэгтэй	2	2%
Ажил хийдэггүй	4	3%
Малчин	1	1%
Хариулахыг хүсэхгүй байна	23	19%
Нийт	**124**	**100%**

БҮЛЭГ НЭГ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүн

Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1-т “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэсэн нэмэлт өөрчлөлт орсон (Монгол Улсын Үндсэн хууль, 1992). Тус нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж, 78 гишүүн олныг төлөөлж, 48 гишүүн хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар сонгогдож нийт 126 гишүүнтэй болсон (Сонгуулийн ерөнхий хороо, 2024).


Сонгуулийн үр дүнд Монгол Ардын намаас сонгуулийн тойрогт 50, намын жагсаалтаар 18 нийт 68, Ардчилсан намаас сонгуулийн тойрогт 26, намын жагсаалтаар 16 нийт 42, Хүн намаас сонгуулийн тойрогт 2, намын жагсаалтаар 6 нийт 8, Үндэсний Эвслийн жагсаалтаар 4, Иргэний Зориг Ногоон намаас жагсаалтаар 4 нэр дэвшигч тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон (Монгол Улсын Их Хурал, 2024).

Иймд судалгаанд оролцогчдоос “2024 оны УИХ-ын сонгуулиар МАН, АН, ХҮН нам, Үндэсний эсвэл, Иргэний Зориг Ногоон нам УИХ-д суудал авсан. Сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ таны хүлээлтэд нийцэж байна уу?” гэж асуухад 124 хүнээс 114 хариулт ирсэн тул үүнийг 100 хувь гэж тооцсон. Судалгааны үр дүнгээс харвал хариулт өгсөн 10 хүн тутмын 2 нь нийцсэн, 10 хүн тутмын 2 нь нийцэж байгаа ч зарим талаар дутагдалтай, 10 хүн тутмын 6 нь нийцээгүй гэжээ.

Олон улсад хийгдсэн ижил төстэй судалгаануудын “Та сонгуулийн үр дүнд сэтгэл ханамжтай байна уу?” гэсэн асуултад Америкт 34%, Японд 24%, Грект 19%, Энэтхэгт 74% сэтгэл ханамжтай байна гэсэн (Pew Research Center, 2025) нь Монгол улсын иргэд 21% сэтгэл ханамжтай байгаагаас статистик ялгаатай ($p<0.001$) буюу өндөр үзүүлэлт байна.

Өөрөөр хэлбэл 2024 оны сонгуулийн үр дүн иргэдийн хүлээлтэд нийцсэн гэж хариулсан дүн 21% байгаа нь нийцээгүй гэж хариулсан дүн 55% байгаагаас 34%-иар илүү байна. Энэ нь иргэдийн дийлэнх нь 2024 оны сонгуулийн үр дүнд сэтгэл дундуур байгааг илэрхийлж байна.

График 1. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ иргэдийн хүлээлтэд нийцэж байгаа эсэх



Дээрх асуултад хариулт өгсөн 114 хүнээс 49 хүн буюу 43% нь сонгуулийн үр дүн ямар нэг байдлаар хүлээлтэд нийцсэн (нийцсэн 21%, нийцсэн ч дутагдалтай 22%) гэж хариулсан. Ийнхүү хариулсан хүмүүсийг 100% гэж үзээд 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ судалгаанд оролцогчийн хүлээлтэд нийцэж буй шалтгаануудыг доорх графикт харуулав.

Хүлээлтэд нийцэж буй шалтгаан нь 2024 оны УИХ-ын сонгууль холимог тогтолцоогоор явагдсанаар олон намын төлөөлөл УИХ-д орж, иргэдийн төлөөлөл болсон гишүүд олон талын байр суурийг нээлттэй илэрхийлдэг болсон. Өөрөөр хэлбэл, УИХ-д МАН-ын хүчтэй сөрөг хүчин болох АН олон суудал авснаас гадна өмнө сонгогдож байгаагүй улс төрийн намууд болон жагсаалтаар санхүүгийн боломжгүйгээс УИХ-ын сонгуульд өрсөлдөж чаддаггүй байсан шинэ, залуу гишүүд орж ирснээр сөрөг хүчний төлөөлөл бүрдсэн.

Жагсаалтаар салбар салбарын чадварлаг, залуусын дуу хоолой болсон Г.Лувсанжамц, М.Нарантуяа-Нара зэрэг хүмүүс сонгогдон зоригтой байр суууриа илэрхийлж байгаа нь өмнөх УИХ-аас ялгаатай харагдаж байна.

Нөгөөтээгүүр одоогийн УИХ-аас хэлэлцэн, баталж буй хуулиуд Үндсэн хуулийн өөрчлөлтөд нийцэж, илүү хүний эрхийн мэдрэмжтэй байж чадаж байна.

2024 оны сонгуулиар МАН зөв нэр дэвшүүлэлт хийснээр өмнөх сонгуулиуд шиг дийлэнх олонхын санал аваагүй ч УИХ-д олонх болж чадсан. Тиймээс өмнө эхлүүлсэн томоохон төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

Мөн одоогийн УИХ, Засгийн газар өмнөх жилүүдтэй харьцуулахад ил тод, нээлттэйгээр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хүртээмжтэйгээр ажиллаж байгаа нь иргэд олон нийтээс эерэг үнэлгээг авсан байна.

График 2. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ хүлээлтэд нийцэж байгаа шалтгаан



“2024 оны УИХ-ын сонгуулиар МАН, АН, ХҮН нам, Үндэсний эсвэл, Иргэний Зориг Ногоон нам УИХ-д суудал авсан. Сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ таны хүлээлтэд нийцэж байна уу?” гэсэн асуултад хариулсан 114 хүнээс 63 хүн буюу 55% нь 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ хүлээлтэд нийцээгүй хариулсан. Мөн 25 хүн буюу 22% нь нийцэж байгаа ч зарим талаар дутагдалтай байна гэсэн. Иймд 2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүнг хүлээлтэд нийцэхгүй байгаа болон дутагдалтай байгаа шалтгааныг тайлбарласан 88 хариултыг 100% гэж үзээд ийнхүү үнэлж буй шалтгааныг график 3-т харуулав.

Сонгуулийн үр дүнд 126 гишүүнтэй, 5 нам, эвслийн төлөөлөл бүрдсэн ч үр дүнтэй ажиллаж чадахгүй байна. Харин ч 126 гишүүнтэй болсноор төр хэт данхайж, сонгогдсон гишүүд нь ажлаа мэдэхгүй, хувийн тоглолт хийж, бие биеэ үл хүндэтгэж, хоорондоо зөрчилдөж, чуулгандаа суухгүй байдал ажиглагдсан.

УИХ-ын сонгуулиар олон намын төлөөлөл сонгогдоно гэсэн хүлээлттэй байсан ч сонгогчдын боловсрол муу байгаагаас өмнөхтэйгөө ижилхэн сонголт хийж МАН дахин олонх болсон нь таалагдаагүй. Өөрөөр хэлбэл АН эрх баригч болж ХҮН нам илүү олон суудал аваасай гэж хүссэн. Одоогийн 126 гишүүнтэй УИХ-д нам эвслүүдийн эзлэх жин хэтэрхий их зөрүүтэй байх нь улс орны тогтвортой байдалд муу гэжээ.

Хэдийгээр 5 нам, эвсэл УИХ-д суудал авсан ч сөрөг хүчний үүргээ гүйцэтгэхгүй, хамтарсан Засгийн газарт орж ажилласан. Угтаа МАН олонх суудал авсан бол Засгийн газраа дангаар бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ёстой. Гэтэл хамтарсан Засгийн газар бүрдүүлж, сайд дарга нарыг удаа дараалан сольж, чадваргүй хүмүүсийг албан тушаалд томилон (Ерөнхий сайд Г.Занданшатар болон боловсролын сайд П.Наранбаяр нар) нь төрийн ажлын тогтвортой байдлыг алдагдуулсан.

Ийм Засаг төрийн тогтворгүй байдал нь ард иргэдэд тулгамдаж буй бодит асуудлууд болох инфляц, үнийн өсөлт, цалин тэтгэврийн хүрэлцээгүй байдлыг хэвээр үргэлжлэх шалтгаан болж байна. Татварын ачаалал өмнөх үеүдээс нэмэгдэж ард иргэдийн нуруун дээр ирэх ачаалал өссөн. Гэтэл татварын мөнгийг бордюр солих зэрэг үр ашиггүй зүйлд зарцуулсаар байна.

Мөн ард түмний танихгүй, жагсаалтаар сонгогдсон гишүүд тойргуудын асуудлыг ойлгож, анхаардаггүй байдал байна. Гишүүд хөдөө орон нутгийн иргэдэд хүрч ажиллах нь бага бөгөөд асуудлыг шийдвэрлэхдээ цогцоор нь шийдвэрлэдэггүйн улмаас ахиц гарахгүй байна. Тухайлбал зураг төслөө гаргаад өгвөл сургууль барьж өгнө гэсэн ч аймагт зураг төсөл гаргах санхүүгийн боломж, боловсон хүчин байхгүйн учраас энэ асуудал шийдвэрлэгдээгүй тохиолдол гарсан. Мөн Халзанбүргэдэйн төслийг хангалттай явуулж чадаагүй, сонсгол нь сайн хэрэгжээгүй нь урам хугалсан. Дийлэнх шийдвэр, хууль тогтоомжууд дунд болон дээд давхаргад төвлөрдөг тул доод давхаргын иргэдэд хүртээмжгүй байдаг гэжээ.

Зарим оролцогч улс төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтнууд бүгд хоорондоо тохиролцож хуйвалдсан гэж хардаж байна гэсэн байна.

График 3. 2024 оны сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ хүлээлтэд нийцэхгүй байгаа шалтгаан




“2024 оны сонгуулиар МАН олонх болж, ялалт байгуулсан. Ялалтын шалтгааныг Та юу гэж харж байна вэ?” гэсэн асуултад бүх оролцогч хариулсан бөгөөд оролцогчдын 31% буюу 10 хүн тутмын 3 нь МАН 100 жилийн түүхтэй, рейтинг өндөртэй, бусад намтай харьцуулахад хийж бүтээсэн зүйлтэй учраас ялалт байгуулсан гэж хариулсан.

Оролцогчдын үзэж буйгаар, МАН эв нэгдэлтэй, нэгдсэн удирдлагатай байж, танигдсан, боловсролтой салбар бүрийн чадварлаг залуусыг жагсаалтад нэр дэвшүүлж сонгуулийн компанит ажлаа сайн хийсэн. МАН-ын мөрийн хөтөлбөр (байгалийн баялгийн зөв ашиглалт, татвар нэмэхгүй, эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлэх) таалагдаж, хэрэгжинэ гэж сонгогчид итгэсэн байна.

Мөн холимог тогтолцоогоор, томсгосон тойргоор сонгууль зохион байгуулагдсан нь танигдсан нэр дэвшигчтэй, мөнгөтэй нам болох МАН-д давуу тал болж МАН-ын гишүүд, ахмадуудын ирц, намаас томилогдсон эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын сүлжээ нь ялалтын суурь болдог гэжээ.


Зарим оролцогчдын тайлбарлаж буйгаар, МАН гаднын улсаас санхүүжилт авч, сонгуулийн хар технологи ашигласан бөгөөд нөгөө талд өрсөлдөгч намуудын нэр дэвшүүлэлт сул, дотроо хагаралтай, мөнгөгүй байсан. Сонгуулийн өмнө цалин, тэтгэвэр нэмж, Шинэ хоршоо хөдөлгөөнийг эхлүүлсэн зэрэг нөхцөл байдал үүссэн. Иймд сонгогчдын боловсрол тааруу байсан нь МАН ялалт байгуулах шалтгаан болсон гэжээ.

График 4. 2024 оны сонгуулиар МАН олонх болж, ялалт байгуулсан шалтгаан



“2024 оны сонгуулиар АН хүчтэй сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авч чадсан. Тус үр дүнд хүрч чадсан шалтгаан нь юу вэ?” гэсэн асуултад 124 судалгаанд оролцогч 100% хариулсан бөгөөд 69% нь АН сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авч чадсан гэдэгтэй санал нийлсэн бол 9% нь АН үүнээс илүү суудал авах боломжтой байсан ч чадаагүй гэсэн тайлбар хэлсэн байна. Харин 22% нь энэ талаар тодорхой ойлголтгүй байна гэжээ.

График 5. 2024 оны УИХ сонгуулийн АН-ын үр дүнд хандах олон нийтийн хандлага



2024 оны УИХ-д Ардчилсан нам сөрөг хүчин болохуйц хангалттай тооны суудал авч чадсан гэдэгтэй судалгаанд оролцогчдын 69% нь санал нэгдсэн. Ийнхүү үзэж буй хүмүүсийг 100% гэж үзээд 86 хүний хариулт дээр шалтгааныг тодруулахад дийлэнх хариулт буюу 20% нь АН-ыг олон тооны суудал авч чадвал өмнөх удаагаас хүчтэй сөрөг хүчин болж ажлаа амжилттай хийх боломжтой болно гэж харж байсан.

Мөн иргэд МАН-ыг хамтарсан Засгийн газар байгуулан ажилласныг эсэргүүцэж байгаа бөгөөд дахин хамтарсан Засгийн газар байгуулахаас АН-ыг сэргийлнэ гэж үзсэн тул саналаа өгсөн.


2024 оны сонгуульд өрсөлдөхдөө 2020 оны сонгуулийн үетэй харьцуулахад АН шинэ залуу, өрсөлдөхүйц нэр дэвшигчдийг оролцуулж, намын даргаа солих зэргээр дотоод бүтцээ багагүй өөрчилсөн бөгөөд хоорондоо эв нэгдэлтэй болсон нь олон нийтэд таалагдсан. Нөгөөтээгүүр АН залуучууд руу чиглэсэн бодлого хэрэгжүүлж, сонгогчдын дэмжлэгийг авч чадсан. Бүсчилсэн хөгжлийн өөрчлөлтийг яг сонгуулийн өмнө хийсэн нь иргэд АН-д итгэл хүлээлгэх шалтгаан болсон гэжээ.

Мөн АН бол МАН-ын дараа орохуйц хоёр дахь том нам бөгөөд иргэд олон нийтэд бусад намуудаас илүү танигдсан байдаг. Иймээс татвар, валютын ханш өссөн зэрэг шалтгаанаар хүмүүс МАН-аас өөр нам дэмжих хүсэлтэй болсон. МАН-аас залхсан, итгэл алдарсан сонгогчид АН-ыг мөрийн хөтөлбөрийнхөө дагуу сайн ажиллавал иргэдийн амьдрал сайжирна гэж найдсан тул түлхүү АН-ыг сонгосон гэжээ.

Гэвч АН-ыг мөнгө тараасан, сонгуулийн өмнө гэнэт идэвхтэй болж ард түмнийг төөрөгдүүлэн итгэлийг нь олж авсан, АН нөлөө бүхий хүмүүсээ ашиглан байгууллагын удирдлагуудаар ажилчдад мэдээлэл дамжуулсан зэрэг сонгуулийн хар технологиудыг ашигласан гэж үзэж байгаа иргэд байна.

Нөгөө талаас 2024 оны сонгуулийн томсгосон тойргийн систем ч олон суудал авахад нь эерэг нөлөө үзүүлсэн гэжээ.

График 6. 2024 оны сонгуулиар АН сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авсан шалтгаан



2024 оны сонгуулиар АН хүчтэй сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авч чадсан гэдэгтэй судалгаанд оролцогчдын 11 хүн буюу 9% нь санал нийлээгүй тул тус хариултуудыг 100% гэж үзээд график 7-д шалтгааныг харуулав.

Тус хариултыг өгсөн хүмүүс ихэвчлэн АН сонгуульд ялагдсан, үүнээс илүү тооны суудал авч чадах байсан гэжээ. Тодруулбал, АН нь хоорондоо эв түнжин, зохион байгуулалт муутай, хамгийн гол нь намын даргын асуудалтай байсан. Иймд Ардчилсан нам сүүлийн жилүүдэд хангалтгүй ажиллаж улмаар нэр хүнд нь өмнөхөөсөө унасан тул бага санал авсан гэжээ.

Зарим иргэдийн үзэж байгаагаар АН-ын гол дэмжигчид болох залуус сонгуульд ирц багатай оролцсон бөгөөд нөгөө талд МАН мөнгө тарааж санал худалдан авсан нь АН-ын ялагдах шалтгаан болсон. Ийнхүү сонгуульд ялагдсан АН одоо сөрөг хүчний хувьд ажиллаж чадахгүй байгаа буюу Монгол Ардын нам дангаар засаг барьж байгаа гэжээ.

График 7. 2024 оны сонгуулиар АН олонх болоогүй шалтгаан



“ХҮН нам УИХ-д 8 суудал авч, өмнөх сонгуулиудтай харьцуулахад гишүүдийн тоогоо нэмж чадсан. Тус үр дүнд хүрч чадсан шалтгааныг юу гэж бодож байна вэ?” гэсэн асуултад оролцогчид 100% хариулсан бөгөөд 21% буюу 10 хүн тутмын 2 нь 2024 оны УИХ-ын сонгуульд ХҮН намын нэр дэвшигчид нь мэдлэг боловсролтой, салбартаа нэр хүндтэй, авлига албан тушаалын хэрэгт холбогдоогүй, шинэ залуу хүмүүс байсан нь тус үр дүнд хүргэсэн.

ХҮН намын дарга Т.Доржханд, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байсан Д.Энхбат нарын нэр хүнд намын рейтингд эергээр нөлөөлсөн. Мөн ХҮН нам өмнөх жилүүдэд сайн ажиллаж ард иргэдийн итгэл найдварыг хүлээж, гишүүд болон дэмжигчдийнхээ тоог нэмэгдүүлсэн. Ялангуяа залуу сонгогчид ХҮН намд итгэл хүлээлгэдэг бөгөөд 2024 оны сонгуулиар ХҮН намаас гаргасан мөрийн хөтөлбөр ч амьдралд ойр байсан тул ХҮН намыг МАН, АН-тай өрсөлдөхүйц гуравдагч сөрөг хүчин, АН-аас илүү сөрөг хүчин болж чадна гэсэн хүлээлттэй байсан гэжээ.

Нөгөө талаас МАН-тай тохиролцож, санал хуваах зорилгоор нэр дэвшсэн хүмүүс сонгогдож гишүүн болчихсон байх гэсэн хардлага иргэдийн дунд байна.

Мөн холимог сонгуулийн тогтолцоогоор жагсаалтаар нэр дэвшигчид гарах боломжтой болсон нь эерэг нөлөө үзүүлсэн гэжээ.

График 8. Хүн нам УИХ-д 8 суудал авч, өмнөх сонгуулиудтай харьцуулахад гишүүдийн тоогоо нэмж чадсан шалтгаан




1.2. УИХ болон УИХ-д суудал бүхий улс төрийн намуудын талаарх байр суурь

“2024 оны сонгуулиар бүрдсэн 126 гишүүнтэй парламент өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна вэ?” гэсэн асуултад 124 хүн буюу бүх хүн хариулсан. Оролцогчдын 11% нь сайжирсан, 14% нь сайн болон муу тал хосолсон, 26% нь өмнөхөөсөө ялгаагүй буюу хэвээрээ байгаа, 36% нь өмнөхөөсөө муу болсон гэж дүгнэсэн байна.

Өөрөөр хэлбэл 126 гишүүнтэй УИХ өмнөх 76 гишүүнтэй УИХ-аас муу болсон гэж үзэж байгаа нь сайжирсан гэж үзэж байгаагаас 25%-иар илүү хувийг эзэлж байна.

График 9. 2024 оны сонгуулиар бүрдсэн 126 гишүүнтэй парламент өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулсан үр дүн



Одоогийн 126 гишүүнтэй парламентыг өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулахдаа судалгаанд оролцогчдын 3 хүн тутмын 1 буюу 45 хүн муу болсон гэж үзсэн. Ийнхүү үнэлсэн хүмүүсийг 100% гэж үзвэл тэдний 41% нь 126 гишүүнтэй парламент нь өмнөх 76 гишүүнтэй байсан парламентаас үр дүн муутай, ил тод биш ажиллаж байна гэжээ. УИХ 126 гишүүнтэй болсноор төсвийн үргүй зардал нэмэгдсэн тул ард иргэдийн нуруун дээрх ачаа өмнөх үеэс нэмэгдсэн гэжээ.

Мөн гишүүд ажилдаа хайхрамжгүй, ирц оролцоо муутай хандаж байгаа бөгөөд зарим сайд ажлаа сайн мэдэхгүй, хийж чадахгүй байна. Жагсаалтаар гарсан гишүүд аль нэг тойргийг төлөөлж ажиллахгүй байгаа тул тойрогт, сум дүүргүүдэд огт ирж ажилладаггүй, ирсэн гишүүд шагнал гардуулж өгөхөөс өөр зүйл хийж байгаагүй бөгөөд ард түмний төлөөлөл гэхээсээ илүүтэй намынхаа эрх ашгийн төлөө ажилладаг.

Мөн төрийн мөнгийг хувьдаа завшин орлого олох байдал өмнөх жилүүдээс нэмэгдсэн гэсэн хардлага иргэдийн дунд байна. Гэтэл авлига, албан тушаалын хэрэгт нэр холбогдсон гишүүдэд УИХ огт арга хэмжээ авч ажиллахгүй байна гэжээ.

126 гишүүнтэй парламент өмнөх парламенттай харьцуулахад эв түнжин муутай ажиллаж байна. Байнгын зөрчил маргаантай байгаа УИХ-ын гишүүд намын дотоод асуудлуудаасаа өөр асуудал хэлэлцэхээ больж сайд дарга нараа дахин дахин сольж байна. Тиймээс шинэ Засгийн газар ажиллаж эхэлснээс хойш төрийн ажлууд илүү шат дамжлагатай болсон бөгөөд төр оролцох шаардлагагүй бүхий л салбарт оролцдог болсон нь ард иргэдэд хүндрэл учруулж байна.

Одоогийн УИХ дахь олон хүний санал дундаас гарч буй шийдвэрүүд хөрсөн дээр бууж хэрэгждэггүй. Иймд сонгодог парламентын тогтолцоо буюу дээд доод танхимтай байвал илүү дээр гэжээ.

График 10. 126 гишүүнтэй УИХ-ыг өмнөх 76 гишүүнтэй УИХ-тай харьцуулахад муу ажилласан гэж хариулсан шалтгаан



Харин өмнөх 76 гишүүнтэй парламентаас одоогийн 126 гишүүнтэй парламент илүү сайжирсан (11%), сайн муу хосолсон байдлаар ажиллаж байна (14%) гэж 10 хүн тутмын 2 буюу нийт 35 хүн үнэлсэн бөгөөд ийнхүү үнэлсэн хүмүүсийн сайжирсан гэж үзэж буй шалтгаануудыг 100% гэж үзээд доорх графикт харуулав.

Эерэг талаас үнэлсэн хүмүүсийн 36% буюу 10 хүн тутмын 4 нь УИХ-ын үйл ажиллагаанд олон намын оролцоо, өрсөлдөөн, хяналттай болсон гэж үзсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Тэдний үзэж буйгаар олон намын оролцоотой болсон тул батлагдаж буй хууль тогтоомжууд илүү үр өгөөжтэй, төрийн ажил илүү олон шүүлтүүр хяналттай болсон. Мөн ирцийн хувьд 63-аас дээш хүн хууль хэлэлцэж баталж байгаа болохоор илүү итгэж үнэмшиж байна гэжээ.


Мөн олон салбарын шинэ залуу хүмүүс УИХ-д орсон тул илүү богино хугацаанд үр дүнтэй ажиллаж байгаа бөгөөд тэдний дунд эх орныхоо төлөө дугарах зоригтой үгээ хэлдэг гишүүд (М.Нарантуяа-Нара, Г.Лувсанжамц) нэмэгдсэн тул эергээр хүлээж авч байна зэрэг хариултуудыг өгсөн байна.

График 11. 126 гишүүнтэй УИХ-ыг өмнөх 76 гишүүнтэй УИХ-тай харьцуулахад сайжирсан гэж хариулсан шалтгаан



“УИХ-д суудал бүхий 5 нам, эвсэл (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ?” гэсэн асуултад МАН-ын үнэлгээ хамгийн өндөр буюу 2.5, АН-ын үнэлгээ 2 буюу удаах байранд жагсаж байна. УИХ-ын ерөнхий үнэлгээ нь 1.9 бөгөөд бусад намууд 1.6 орчим оноогоор үнэлэгдэж байна.

График 12. УИХ-д суудал бүхий 5 нам, эвсэл (МАН, АН, Хүн нам, Үндэсний эвсэл, ИЗНН) дундаж үнэлгээ



Тайлбар: Хангалтгүй (1), өөрчлөгдсөн зүйлгүй (2), зарим дутагдалтай ч сайн ажиллаж байна (3), сайн ажиллаж байна (4) гэсэн үнэлгээ рүү хувиргав.

Одоогийн УИХ-ын үйл ажиллагааг 52 хүн буюу оролцогчдын 42% нь үнэлсэн дундаж үнэлгээ нь 1.9 буюу хангалгүй түвшинд байна. Бусад 72 хүн тус асуултад хэлж мэдэхгүй байна гэсэн, эсвэл хариулаагүй байна.

Ийнхүү үнэлсэн хүмүүсийг 100% гэж үзвэл 29% нь дулаан, цахилгаан, бензин, бүх төрлийн татвар нэмэгдэж ард түмний амьдрал илүү хүнд болж байгаа нь УИХ үр дүнгүй ажиллаж байгаагийн илрэл гэжээ.

МАН, АН л үүргээ гүйцэтгэж бусад нам, эвслүүд кноп дарахаас өөр үүрэггүй ажиллаж байна. Гишүүдийн зарим хэсэг нь үр дүн гаргаж байгаа ч дийлэнх нь хангалтгүй байна. Иймд бүтэц өөрчлөгдсөн ч өөр зүйл өөрчлөгдөөгүй тул 126 гишүүнтэй парламент байх нь оновчтой эсэх эргэлзээтэй байна гэсэн.

Зарим оролцогчдын үзэж буйгаар гишүүд үр дүнтэй сайн хийсэн ажлаа олон нийтэд хүргэж чадахгүй, муу, сөрөг мэдээлэл л хүргэж байна гэв.

Мөн УИХ гишүүд тойрогтоо хүрч ажиллах байдал нэмэгдсэн гэсэн эерэг үнэлгээг 5%, байгалийн баялгийн 34%-ийг төрийн санд авах хэрэгтэй гэсэн саналыг 3% нь өгчээ.

График 13. УИХ-д суудал бүхий 5 нам, эвслийн (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) үнэлгээний үндэслэл

Дундаж үнэлгээ: 1.9



УИХ-д суудал бүхий 5 нам, эвслийн үнэлгээ болон тухайн үнэлгээ өгсөн үндэслэл шалтгааныг дараах байдлаар харууллаа.

МАН-ыг 88 хүн буюу нийт оролцогдын 71% үнэлсэн дундаж үнэлгээ 2.5 (Хангалтгүй-1, сайн ажиллаж байна-4) буюу дунджаас илүү байна. Ийнхүү үнэлсэн шалтгааныг харвал судалгаанд оролцогчид Монгол Ардын Намыг өмнө ямар байснаасаа сайжирсан зүйл байхгүй гэж 28% буюу 10 хүн тутмын 3 нь үнэлсэн байна.

Мөн үйл ажиллагаа нь идэвхтэй, ачааны хүндийг нь МАН үүрч байгаа тул сайн хэрэгжүүлж байгаа ажлууд бий. Өмнөх жилүүдтэй харьцуулахад МАН ард иргэдэд мэдээлэл, ойлголт хүргэх байдал нь сайжирсан.

Нөгөө талаас сайн муу хосолсон байдлаар ажиллаж байна. Нам доторх хагарал намын үйл ажиллагааг хойш татаж залуу гишүүд нь шинэ санаа гаргах, үзэл бодлоо илэрхийлэхэд хязгаарлагдмал байгаа нь харагддаг гэсэн байна.

График 14. Монгол Ардын намын үнэлгээний үндэслэл

Дундаж үнэлгээ: 2.5



АН-ыг 81 хүн буюу нийт оролцогчдын 65% үнэлсэн дундаж үнэлгээ нь 2 (Хангалтгүй-1, сайн ажиллаж байна-4) буюу өөрчлөгдсөн зүйлгүй гэсэн. Ийнхүү үнэлсэн шалтгааныг харвал 24% нь сөрөг хүчний ажлаа хийж чадахгүй байна, 18% нь хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь тодорхойгүй байна гэжээ.


Өөрөөр хэлбэл АН нийгмийн хүлээлтийг биелүүлж чадахгүй байна, нам доторх хагарал нь намын үйл ажиллагааг хойш татаж байна. Зөв санал санаачилгыг хаах байдлаар сайн муу хосолсон ажлыг хийж байгаа. Тус намын гишүүдийн мэдлэг чадвар хангалтгүй учир сөрөг хүчний ажлаа зөв хийхгүй байна гэж шүүмжилсэн.

Нөгөө талаас үйл ажиллагаа нь идэвхтэй, чадварлаг сөрөг хүчин бөгөөд ард иргэдэд мэдээлэл дамжуулах нь өмнөх жилүүдээс сайжирсан гэжээ.

Зарим оролцогчдын хувьд даргаа саяхан сонгож саяхнаас Засгийн газраасаа гараад сөрөг хүчин болсон тул сайн ажиллах болов уу гэж хүлээж байна гэсэн байна.

График 15. Ардчилсан намын үнэлгээний үндэслэл

Дундаж үнэлгээ: 2.0



ХҮН намыг 60 хүн буюу нийт оролцогчдын 48% үнэлсэн дундаж үнэлгээ нь 1.6 (Хангалтгүй-1, сайн ажиллаж байна-4) буюу хангалтгүй гэж дүгнэж байна. Бусад 64 хүн тус асуултад хариулаагүй, эсвэл хэлж мэдэхгүй гэсэн. Ийнхүү үнэлсэн хүмүүсийг 100 гэж тооцвол 46% нь ХҮН намыг юу хийж хэрхэн ажиллаж байгаа нь тодорхой биш гэж үзсэн.

ХҮН намыг сөрөг хүчин бол гэж сонгосон байтал эрх баригч намтай хамтарч Засгийн газарт ажиллаж байгаа нь буруу. Намын удирдлагууд нь чадвар муутай тул чанартай боловсон хүчин болох намыг гишүүдээ сайн ажиллахад сөргөөр нөлөөлж байгаа нь ХҮН намаас хүсэж байсан хүлээлтийг унагааж байна гэжээ.

Нөгөө талаас ХҮН намын үйл ажиллагаа нь идэвхтэй бөгөөд ард түмэнд хүртээмжтэй ажиллаж байгаа гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

Зарим оролцогчид ХҮН нам УИХ-д цөөн суудал авсан тул одоогоор үр дүнтэй ажиллаж чадахгүй байна гэжээ.

График 16. ХҮН намыг үнэлсэн үнэлгээний үндэслэл

Дундаж үнэлгээ: 1.6



Үндэсний Эвслийг 42 хүн буюу нийт оролцогчдын 34% үнэлсэн дундаж үнэлгээ нь 1.5 (Хангалтгүй-1, сайн ажиллаж байна-4) буюу хангалтгүй гэж дүгнэж байна. Үндэсний эвслийг үнэлсэн хүмүүсийг 100% гэж тооцоод үнэлгээний шалтгааныг харвал одоо юу хийж хэрхэн ажиллаж байгаа нь тодорхой биш гэж 48% нь үнэлсэн нь дийлэнх хувийг эзэлж байна.

Нэг талаас Үндэсний Эвслийн дарга Н.Номтойбаярыг УИХ-ын үйл ажиллагаанд оролцоо сайтай ч бусад гишүүд оролцоо муутай байгаа. Гишүүд нь тодорхой дэмжлэгтэй ч дуу хоолой нь хараат бөгөөд бие даасан байдлаар үзэл бодлоо илэрхийлж чаддаггүй. Мөн Үндэсний эвслийг чанартай боловсон хүчинтэй, сөрөг хүчин хүчин болж ажиллана гэсэн хүлээлтэд хүрэхгүй байна гэжээ.

Зарим оролцогчид Үндэсний эвслийг цөөн суудал авсан тул бүтээмж гаргаж чадахгүй байгаа ч үйл ажиллагаа нь идэвхтэй байна гэжээ.

График 17. Үндэсний эвслийн хэрхэн ажиллаж буйд иргэдийн өгсөн үнэлгээ

Дундаж үнэлгээ: 1.5



Иргэний Зориг Ногоон намыг 39 хүн буюу нийт судалгаанд оролцогчдын 31% нь үнэлсэн дундаж үнэлгээ 1.6 (Хангалтгүй-1, сайн ажиллаж байна-4) буюу хангалтгүй гэж дүгнэж байна. ИЗНН-д үнэлгээ өгсөн хүмүүсийг 100% гэж үзвэл 47% нь юу хийж хэрхэн ажиллаж байгаа нь тодорхой биш гэсэн. Мөн 3% нь тус нам тойргоос санал авч чадаагүй ч жагсаалтаар УИХ-д суудал авсан нь оновчгүй санагдаж байна гэжээ.

Түүнчлэн сөрөг хүчний ажлаа хангалгүй хийж байна гэж 5% нь үнэлсэн бол 22% нь сөрөг хүчний ажлыг тодорхой хэмжээнд гүйцэтгэж байна гэсэн байна. Гэвч цөөн суудал авсан тул үр дүнтэй ажиллаж чадахгүй байна гэжээ.

Мөн М.Нарантуяа-Нара гишүүн амьдралд ойр зөв зүйл ярьдаг шударга хүн тул намын дарга болох хэрэгтэй гэсэн байна.


График 18. Иргэний Зориг Ногоон Намын хэрхэн ажиллаж буйд иргэдийн өгсөн үнэлгээ

Дундаж үнэлгээ: 1.6



УИХ-д суудал бүхий 5 нам, эвслээс ямар хүлээлттэй байгааг тодруулсан. Судалгаанд оролцогч 124 хүн буюу 100% тус асуултад хариулсан бөгөөд МАН-аас 94%, АН-аас 86%, ХҮН намаас 89%, Үндэсний эвслээс 71%, ИЗНН-аас 70% нь ямар нэг хүлээлттэй байна гэжээ. Өөрөөр хэлбэл эрх баригч МАН-аас хүлээх хүлээлт хамгийн өндөр, ИЗНН-аас хамгийн бага байна.

График 19. УИХ-д суудал бүхий намуудаас иргэд хүлээлттэй байгаа эсэх үр дүн



Судалгаанд оролцогчид УИХ-д суудал бүхий МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН-уудаас бүгдээс нь сонгуулиар өгсөн амлалтуудаа биелүүлж, ард түмний аж амьдралыг сайжруулах буюу цалин тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн зөв бодлого чиглэл явуулах тал дээр хүлээлттэй байна гэсэн. Иймд УИХ-ын гишүүд дотоод зөрчил багатай ажиллаж авлига хээл хахууль, хулгай зэрэг асуудлаа шийдэх тал дээр анхаарах шаардлагатай байна гэсэн.

Мөн бие даасан хараат бус үйлдвэржилтийн орон болж тог цахилгаан, шатахуунаа дотооддоо хангадаг болох, байгалийн баялгийг зөв хуваарилах, зарцуулах асуудлуудыг шийдвэрлэхэд бүх намын оролцоо шаардлагатай гэжээ.

Монгол Ардын Намаас иргэдийн хүлээж буй хүлээлтийн дийлэнх хувьд 2025 оны хөгжлийн төлөвлөгөөндөө хүрэхэд анхаарч хүлээгдэж буй төслүүдийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч төсвийг тэнцүүлэх, бондуудыг зөв ашиглахад анхаарах гэсэн.

Түүнчлэн нийгэм, ард иргэдийн амьдралд тулгамдаж буй асуудлууд болох цалин, тэтгэврийн асуудлыг шийдвэрлэж татварын бодлогыг багасгах. Дулааны цахилгаан станц, утааны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч явц болон үр дүнг ард иргэддээ тодорхой хэлж өгдөг байхыг хүлээж байгаа бөгөөд МАН Засгийн газраа дангаараа бүрдүүлж ажиллах хэрэгтэй гэжээ.

АН, ХҮН нам, Үндэсний Эвсэл, ИЗНН-уудыг сөрөг хүчний ажлаа сайн хийхийг хүссэн.

ХҮН нам, Үндэсний Эвсэл, ИЗНН-уудыг МАН, АН намуудын дарангуйллаас ард түмнээ салгах гуравдагч боловсон хүчний хувьд зөв тактик, зорилготой ажиллаасай гэжээ.

Хүснэгт 4. УИХ-д суудал бүхий МАН, АН, Хүн нам, Үндэсний эвсэл, ИЗНН-уудаас иргэдийн хүлээлт

Хүлээлтүүд	МАН	АН	ХҮН	ҮЭ	ИЗНН
Татварын хувь хэмжээг багасгах	5%				
Цалин, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх	7%	2%	2%	3%	3%
Сонгуулиар өгсөн амлалтуудаа биелүүлж, ард түмний аж амьдралыг сайжруулах	31%	25%	41%	47%	47%
Дулааны цахилгаан станцын асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч явц болон үр дүнг ард иргэддээ тодорхой хэлж өгдөг байх	3%				
Утааны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч явц болон үр дүнг ард иргэддээ тодорхой хэлж өгдөг байх	3%				
Хүлээгдэж буй төслүүдийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч явц болон үр дүнг ард иргэддээ тодорхой хэлж өгдөг байх	9%				
2025 оныхоо хөгжлийн төлөвлөгөөндөө хүрэх тал дээр илүү сайн чиглээд ажиллаасай	3%				
Засгийн газраа дангаараа бүрдүүлж ажиллаасай	3%				
Стратегийн ордуудын асуудлуудыг шийдвэрлэх	3%				
Төсвийн тэнцлийг тэнцүүлэх	3%				
Бондуудыг зөв ашиглах /дэмий зарлага гаргахгүй байх/	4%				
Өндөр хүлээлттэй байна	9%				
Байгалийн баялгийг зөв хуваарилах, зарцуулах	8%	3%	4%	5%	5%
Бие даасан хараат бус үйлдвэржилтийн орон болж тог цахилгаан, шатахуунаа дотооддоо хангадаг болох	5%	7%	11%	10%	11%
Дотоод зөрчил багатай ажиллаасай	1%	13%	9%	5%	5%
Эдийн засгийн зөв бодлого чиглэл явуулах	1%				
Авлига хээл хахууль, хулгай зэрэг асуудлаа шийдэх	3%	8%	9%	5%	5%
Сөрөг хүчний ажлаа сайн хийгээсэй		43%	17%	17%	16%
МАН, АН намуудын дарангуйллаас ард түмнээ салгах гуравдагч боловсон хүчний хувьд зөв тактик, зорилготой ажиллаасай			7%	8%	5%
Байгаль орчин талдаа илүү хүрч ажиллаасай					3%

“Таны бодлоор одоогийн УИХ-ын үйл ажиллагааг сайжруулахын тулд УИХ-д суудал бүхий 5 нам (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) хэрхэн ажиллах хэрэгтэй вэ?” гэсэн асуултад иргэд 100% хариулсан бөгөөд УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах дараах үйл ажиллагаануудыг чухалчилсан байна. Үүнд:


Намууд болон УИХ гишүүд хоорондын албан тушаалын маргааны оронд ард иргэдийн амьдралд тус нэмэр болохуйц асуудлуудыг ёс зүйтэй, эв нэгдэлтэйгээр хамтран ажиллаж шийдвэрлэх хэрэгтэй. Ингэхдээ ахмад болон туршлагатай гишүүдийн мэдлэг чадварыг ашиглах буюу залуу гишүүд нь туршлага суралцах хэрэгтэй. Нөгөө талаас МАН, АН намууд залуу гишүүддээ боломж олгож, залуу гишүүд нь зоригтойгоор үзэл санаагаа илэрхийлэх шаардлагатай байна.

Мөн УИХ-ын үйл ажиллагааг явуулахдаа гишүүдийн ирц оролцоон дээрээ хяналт тавьж хариуцлага тооцох, хяналтын системийг сайжруулах, УИХ-ын болон сонгуулийн зарим дүрмүүдийг шинэчилж чангатгах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хуулийн төсөл дэвшүүлж байгаа гишүүд илүү нарийн тодорхой зүйл ярьж ард иргэдэд үнэн зөв ойлголт өгөх шаардлагатай байна.

Гишүүн бүр ард түмний төлөөлөл болж сонгогдсоны хувьд намын бодлогыг үл харгалзан сонгуулийн мөрийн хөтөлбөр дээрх амлалтуудынхаа дагуу ард иргэдийн эрх ашиг, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж ажиллах ёстой.

Нэн тэргүүнд, үндэсний үйлдвэрлэл болон түүхий эд боловсруулагчдыг дэмжиж ажиллах буюу арьс шир боловсруулалтын үйлдвэрүүдэд анхаарал хандуулж үнэгүйдлийг арилгаж өгөх, хөдөө орон нутаг болон сум дүүргүүдэд хүрч ажиллах, тэтгэврийг нэмэгдүүлэх, үнийн өсөлт, инфляцыг тогтвортой барих, экспорт болон импортыг өргөжүүлэх, байгалийн баялгийг ард түмэнд түгээх, зөв хуваарилж зарцуулах зэрэг үйл ажиллагаа нь УИХ-ын үйл ажиллагааг сайжруулна гэж үзжээ.

График 20. УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах тал дээр иргэдийн санал




1.3. Засгийн газрын үйл ажиллагаа

“Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар өнгөрсөн хугацаанд хэр зэрэг ажилласан гэж Та бодож байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчид 100% хариулснаас 89 хүн буюу 71.7% нь үнэлгээ өгсөн үг ашигласан байна. Иймд тус хариултуудыг хангалтгүй буюу муу (1), дундаж буюу сайн муу хосолсон (2), боломжийн (3), сайн (4) гэсэн оноо луу хувиргахад дундаж үнэлгээ 2.85 буюу боломжийн ажилласан гэсэн дүгнэлтэд ойртож байна. Үнэлгээ өгсөн судалгаанд оролцогчдыг 100% гэж үзвэл дийлэнх буюу 37% нь сайн ажилласан гэж үзжээ.

График 21. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар өнгөрсөн хугацаанд хэр зэрэг ажилласан гэж үзэж буй иргэдийн үнэлгээ

Дундаж үнэлгээ: 2.85



Тайлбар: Хангалтгүй (1), дундаж буюу сайн муу хосолсон (2), боломжийн (3), сайн ажиллаж байна (4) гэсэн үнэлгээ рүү хувиргав.

Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг сайн, боломжийн ажилласан гэж үнэлгээ өгсөн оролцогчдын 63% буюу нийт 56 хүн үзсэн. Тэдгээр оролцогчдын үзэж буйгаар Л.Оюун-Эрдэнэ нь улсаа хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж нэлээд хэдэн уурхай, томоохон объектуудыг төрд буцаан авч, хулгай луйврыг илрүүлэхээр зоригтой, зүтгэлтэй ажилласан. Мөн нийгэмд болж бүтэхгүй байгаа асуудлыг зоригтойгоор нийтэд мэдээлэх гэсэн.

Л.Оюун-Эрдэнийн 5 Ш ажиллагаа таалагдаж байсан. Үүний ачаар иргэд баялгийн сангаасаа хувь хүртдэг болсон нь ард түмнийхээ нуруунаас ачааг нь хөнгөлсөн үйл явдал болсон гэжээ.

Мөн Л.Оюун-Эрдэнэ зоригтой шударга гэж анх гарч ирсэн бөгөөд цар тахлын хэцүү үед ажлаа амжилттай хийхийг хичээсэн ба Монгол Улсад хөрөнгө оруулалт татах чиглэлд тодорхой ахиц гаргасан гэж үнэлэгдсэн байна.

График 22. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг сайн ажилласан гэж дүгнэсэн шалтгаан




Харин Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг хангалтгүй, дундаж ажилласан гэж нийт оролцогчдын 38% буюу 41 хүн үнэлсэн байна. Ийнхүү үнэлсэн хүмүүсийг 100% гэж үзвэл 21% буюу 19 хүн хийсэн ажлууд нь тодорхой үр дүнд хүрч амжаагүй гэжээ.

Мөн төрийн эрх авах шоу хийж олон удаа худлаа ярьсан, Алсын хараа 2050 гэх мэт том амлалтууд нь үр дүнд хүрээгүй тул ард түмний нүдэнд харагдах, амьдралд ойрхон бодит ажил болон ямар нэг өөрчлөлт хийгээгүй байна. Энэ хугацаанд инфляцын түвшин өссөн.

Хүч гаргаж төрийн албаны олон салбарт давхардсан олон ажил хийсэн нь үр дүн, хэрэгцээ багатай байсан. Засгийн газрын бүтцийг томсгосон нь асар их үргүй зардал гаргасан бөгөөд сөрөг хүчин хийж байх ёстой намуудаа бүгдийг нь Засгийн газартаа оруулж эрх мэдэлтнүүдийн дунд элит бүс үүсгэсэн. Иймд хийж байгаа ажлуудад эргээд хяналт, гүйцэтгэлийн шалгалт их муухан хийгдсэн. Магадгүй өөрийнх нь потенциал хийж байсан ажилд нь тохирохгүй байсан гэжээ.

Нэг талаас нам доторх болон улс төрийн бүлэглэлүүдийн нөлөө, дарамт саад болсон тул ажлаа хангалттай хийж чадаагүй байж болох ч нөгөө талаас ард түмний мэдэх ёстой байсан асуудлуудыг нь хаагаад нуугаад орхисон тул муу ажилласан гэж үнэлж байгаа гэж тайлбарласан.


График 23. Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийг хангалтгүй ажилласан гэж дүгнэсэн шалтгаан



Харин “Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар хэр зэрэг ажиллаж байна вэ? Сайн бол яагаад, үгүй бол яагаад?” гэсэн асуултад оролцогчид 100% хариулснаас 33 хүн буюу 27% нь үнэлгээ ашигласан бол дийлэнх нь буюу 38% нь дүгнэхэд эрт байна гэсэн. Харин 35% нь асуултад хариулаагүй байна. Үнэлгээ өгсөн оролцогчдын хариултыг хангалтгүй буюу муу (1), дундаж буюу сайн муу хосолсон (2), боломжийн (3), сайн (4) гэсэн оноо руу хувиргахад дундаж үнэлгээ 2.06 буюу сайн муу хосолсон байдлаар дундаж үнэлгээтэй байна.

График 24. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ

Дундаж үнэлгээ: *2.06*



Тайлбар: Хангалтгүй (1), дундаж буюу сайн муу хосолсон (2), боломжийн (3), сайн ажиллаж байна (4) гэсэн үнэлгээ рүү хувиргав.

Нийт судалгаанд оролцогчдын 71% буюу дүгнэхэд эрт байгаа ч өндөр хүлээлттэй байна, дундаж, боломжийн, сайн ажиллаж байна зэргээр хариулсан 88 хүнийг 100% гэж тооцож график 25-д шалтгааныг харуулав.

Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газрыг эергээр дүгнэсэн хүмүүсийн дийлэнх нь дүгнэхэд эрт байгаа ч туршлагатай, боловсролтой хүн учраас өндөр хүлээлттэй байна гэсэн.

Түүнчлэн Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар 2025 онд маш муу хийсэн төсвийг сайжруулах тал дээр Г.Занданшатар сайн ажиллаж төрийн компаниудыг болон хэрэгцээгүй давхардсан орон тоог цөөлж улсын төсвийг танах олон чухал ажил хийсэн. Одоогоор ил тод, нээлттэй ажиллаж байгаа бөгөөд валютын нөөцийг нэмэгдүүлсэн.

Мөн Л.Оюун-Эрдэнийн бодлогыг үргэлжлүүлж өөрийн бодлогыг бас оруулаад идэвхтэй ажиллаж байна гэжээ.

График 25. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар сайн ажиллаж байна гэж дүгнэсэн шалтгаан




Хангалтгүй ажиллаж байна гэж үзсэн судалгаанд оролцогчдын 41% нь одоогоор ажиглагдсан тоймтой зүйл байхгүй байна гэсэн.

Мөн гаргаж байгаа шийдвэрүүд нь амьдралд хэрэгцээтэй бус буюу маш сүртэй эхэлсэн ажлууд үр дүнд хүрээгүй. Үргүй зардлыг багасгасан нь сайн ажил гэхээсээ илүү хийх л ёстой хэвийн ажил тул үүнийг магтмааргүй байна гэжээ.

Түүнчлэн, баялаг бүтээгч нарыг дэмжээгүй бөгөөд өмнөх төслүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа. Энэ хугацаанд үнийн өсөлт болон төрийн албан хаагчдын тоо хэтэрхий их нэмэгдсэн.


Хувь хүн талаасаа яг өөрийн гэсэн бодолгүй буюу туйлбаргүй бөгөөд улс төрд эмх замбараагүй байдал үүсгэсэн гэж шүүмжилжээ.

График 26. Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар хангалтгүй ажиллаж байна гэж дүгнэсэн шалтгаан



“Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас ямар хүлээлттэй байна вэ?” гэсэн асуултад 65% нь тодорхой хүлээлттэй байгаагаа дурдсан бол 18% нь мэдэхгүй, 17% нь удахгүй намын дарга солигдох үед Засгийн газар солигдох тул хүлээлт үүсгэх шаардлагагүй гэсэн хариулт өгсөн байна.

График 27. Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас хүлээлттэй байгаа эсэх



Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас хүлээлттэй байгаа 81 оролцогч буюу нийт оролцогчдын 65%-ыг 100% гэж тооцож график 28-д оролцогчдын хүлээлтүүдийг харуулав.

Судалгаанд оролцогчид цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хүртээмжтэй болгох, инфляцыг бууруулах, татварыг бууруулах зэргээр ард иргэдийн амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн. Тус асуудлуудтай холбогдуулан зарим иргэд шаталсан татварыг дэмжихгүй байна, бүгд ижил тэгш татвар төлөх байдлаар татварын суурийг нэмэгдүүлэх хэрэгтэй, тэтгэврийг нэмэхдээ тухайн хүний төлсөн НДШ-д тулгуурлахгүй бол татвар төлөгчдийн идэвх буурах тул тус асуудлыг зөв чиглүүлэх шаардлагатай гэж санал бодлоо хуваалцсан.


Мөн Засгийн газрыг эмх цэгцэд оруулж үйл ажиллагааг илүү үр ашигтай болгож, УИХ-ын гишүүдийнхээ хангамжийг танах зэргээр төсвийн тэлэлтийг багасгах. Оюутолгойн гэрээг сайжруулах, байгалийн баялгийн хулгайг илрүүлж хуулийг чанга болгох тал дээр зоригтой ажиллаж, гаргасан шийдвэрүүддээ эзэн болоосой хүлээлттэй байна.

Түүнчлэн, багш эмч нарын саналуудыг хүлээж авч Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёл боловсрол гэх мэт бүхий л салбарт тулгамдсан асуудлыг шийдэх, хийж буй ажлуудаа тогтвортой ил тод байлгах хэрэгтэй.

Цаашлаад, түүхий эдээ боловсруулах, баяжуулах үйлдвэржүүлэлт хийх шаардлагатай. Мөн хийн хоолойн болон бусад хүлээгдэж буй том төслүүдийн ажлыг урагшлуулах шаардлагатай гэжээ.

Зарим оролцогчид Ерөнхий сайд өөрөө ажлын туршлагатай хүн тул Засгийн газрын үйл ажиллагааг зөв чиглэл рүү явуулж өгөх байх гэсэн байна.


График 28. Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас хүлээх хүлээлт



БҮЛЭГ ХОЁР. УИХ-Д СУУДАЛ БҮХИЙ 5 НАМ, ЭВСЛИЙН ДАРГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ХҮЛЭЭЖ БУЙ ХҮЛЭЭЛТ


“МАН-ын намын даргын сунгаанд Ерөнхий сайд Г.Занданшатар, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нар өрсөлдөхөөр байна. Та хэнийг нь МАН-ын дарга байхад тохирно гэж харж байна вэ?” гэсэн асуултад нийт оролцогчдын 20% нь Г.Занданшатар, 17% нь Д.Амарбаясгалан гэжээ. Судалгаанд оролцогчдын 31% нь хэнийг нь ч дэмжихгүй гэсэн хариулт өгсөн бол 4% нь хэн нь ч болсон хамаагүй хамтраад ажиллах хэрэгтэй гэсэн байна.

График 29. МАН дараагийн даргад тохирох хүн




Г.Занданшатарыг Монгол Ардын Намын дараагийн дарга болоход тохирно гэж 25 хүн үзсэн бөгөөд ингэж хариулсан оролцогчдыг 100% гэж тооцоод ийнхүү үзсэн шалтгааныг график 30-д харуулав. Тус оролцогчдын үзэж буйгаар Г.Занданшатар авлигаас ангид, хариуцлагатай, үгээ зоригтой хэлдэг шударга, мөн олон жил УИХ-ын гишүүн байсан тул туршлага, нэр хүндийн хувьд илүү сайн тохирох хүн бөгөөд хийгдэж буй ажлуудыг тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд одоогийн Ерөнхий сайд намын дарга байх нь тохиромжтой гэжээ.

График 30. Дараагийн МАН-ын даргад Г.Занданшатар тохирно гэж үзсэн шалтгаан



Монгол Ардын Намын дараагийн даргад Д.Амарбаясгаланг тохирно гэж 22 хүн үзсэн бөгөөд тус оролцогчдыг 100% гэж үзвэл оролцогчдын дийлэнх буюу 80% нь тус гишүүнийг ёс зүйтэй, хариуцлагатай, 20% нь аливаа асуудалд шийдвэртэй ханддаг гэсэн байна.


График 31. Дараагийн МАН-ын даргад Д.Амарбаясгалан тохирно гэж үзсэн шалтгаан



Хэнийг нь ч дэмжээгүй судалгаанд оролцогчид хоёр нэр дэвшигч хоёул сул талтай, туршлага дутуу бөгөөд нүдэнд харагдахуйц юм хэн нь ч хийгээгүй тул хоорондоо ялгаагүй санагдаж байна. Иймээс өөр хүн дэвшээсэй гэж хүссэн.

Мөн хоёр нэр дэвшигч хагаралдаж нэг нь нөгөөгийнхөө асуудлыг гаргаж ирж буй тул ажиглах нь зөв, цаг хугацаа харуулах байх гэжээ.

График 32. МАН-ын намын даргын сунгаанд Ерөнхий сайд Г.Занданшатар, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нарын хэнийг нь ч дэмжээгүй шалтгаан



Судалгаанд оролцогчдоос Ерөнхий сайд Г.Занданшатар МАН-ын дарга болбол ямар хүлээлттэй байгаа талаар тодруулахад нам дотор үүссэн зөрчлөө шийдвэрлэж зөв сайн ажиллах, улмаар засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж авлига, авлига албан тушаал, нүүрсний хэрэгт холбогдсон гишүүдэд хариуцлага тооцох, нийгэмд тулгамдаад буй цалин, тэтгэврийн доод хэмжээг нэмж, үнийн өсөлт, инфляцын асуудлаа шийдвэрлэх гэсэн хүлээлтүүдийг хэлсэн байна.

Харин УИХ-ын дарга Д.Амарбаясгалан МАН-ын дарга болбол ямар хүлээлттэй байгаа талаар тодруулахад илүү сайн ажиллах байх гэж 41% нь хариулсан байна. Мөн

эдийн засаг, татварын бодлогыг сайжруулах, залуусын дэмжлэгийг илүү их авах, нүүрсний хулгайг ил болгох зэрэг хүлээлтүүдтэй байна гэсэн.

АН-ын даргаар сонгогдсон УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлийг хэрхэн ажиллана гэсэн хүлээлттэй байгааг тодруулахад залуусаар багаа бүрдүүлж, сайн сөрөг хүчин болж ажиллах хэрэгтэй гэсэн байна. Мөн иргэдэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, уул уурхай тал руугаа анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй гэсэн.

ХҮН намын дарга Т.Доржхандыг намын даргын үүргийнхээ дагуу сайн ажиллаж их зүйл хийх байх, байгаль орчинд анхаарч ажиллаасай гэжээ. Гэвч хариулт өгсөн оролцогчдын 10 хүн тутмын 2 нь МАН-ын хүн гэж бодсон тул итгэх итгэл унасан гэсэн хариулт өгсөн байна.

Үндэсний Эвслийн дарга Н.Номтойбаярыг иргэд их зүйл хийх байх гэж дэмжиж байгаа бөгөөд нөөц бололцоогоо ашиглан Дорнод аймагт их зүйл хийсэн шигээ ажиллах хэрэгтэй гэсэн. Гэвч зарим оролцогчид тус гишүүнийг онгироо, гэмт хэрэгтэн гэж хардаг зэргээр тодорхойлжээ.

ИЗНН-ын дарга Б.Батбаатарыг сайн ажиллаж чадвал Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж магадгүй бөгөөд УИХ-ын ёс зүйд анхаарч сайн ажиллаасай гэсэн. Гэвч өөрийнхөө эрх ашгийн төлөө явдаг бөгөөд хийсэн ажил нь харагддаггүй гэж шүүмжилжээ.

Судалгаанд оролцогчдын 17% нь Г.Занданшатарыг, 9% нь Д.Амарбаясгаланг, 3% нь О.Цогтгэрэлийг намын дарга байхад тохиромжгүй гэж үзсэн.

Мөн судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь тус намын дарга нараас ямар нэг хүлээлтгүй байгаа, эсвэл хэлж мэдэхгүй байна гэсэн. Тодруулбал, МАН-ын даргаас 10 хүн тутмын 4 нь, АН-ын даргаас 10 хүн тутмын 5 нь, ХҮН намын даргаас 10 хүн тутмын 4 нь, Үндэсний Эвслийн даргаас 10 хүн тутмын 5 нь, Иргэний Зориг Ногоон намын даргаас 10 хүн тутмын 8 нь хүлээлтгүй, эсвэл хэлж мэдэхгүй байна гэж хариулсан.

Хүснэгт 5. УИХ-д суудал бүхий 5 нам, эвслийн дарга нараас иргэдийн хүлээж буй хүлээлтүүд

МАН-ын дарга Г.Занданшатар болбол хүлээх хүлээлт	МАН-ын дарга Д.Амарбаясгалан болбол хүлээх хүлээлт	АН-ын дарга О.Цогтгэрэлээс хүлээх хүлээлт	ХҮН намын дарга Т.Доржхандаас хүлээх хүлээлт	Үндэсний эвслийн дарга Н.Номтойбаяраас хүлээх хүлээлт	ИЗНН-ын дарга Б.Батбаатараас хүлээх хүлээлт
- Нам дотор үүссэн зөрчлөө шийдвэрлэх-12% - Сайн ажиллах байх-12% - Цалин, тэтгэврийн доод хэмжээг нэмж, үнийн өсөлт, инфляцын асуудлаа шийдвэрлэх-8% - Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах-5% - Авлига албан тушаал, нүүрсний хэрэгт холбогдсон УИХ-ын гишүүдэд хариуцлага тооцох-3%	- Илүү сайн ажиллах байх-41% - Эдийн засаг, татварын бодлогыг сайжруулах- 8% - Залуусын дэмжлэгийг авах -3% - Нүүрсний хулгайг ил болгох-2%	- Залуусаар багаа бүрдүүлж ажиллах–29% - Сайн сөрөг хүчин байх-14% - Иргэдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх-4% - Дэмждэг-4% - Уул уурхай тал руугаа ажиллана гэж харж байна-1%	- Намын даргын үүргээ сайн биелүүлэх-18% - Их зүйл хийх байх-13% - Байгаль орчинд анхаарч ажиллах-5%	- Дэмждэг, их зүйл хийх байх -35% - Нөөц бололцоогоо ашиглах -7% - Дорнод аймагт их зүйл хийсэн шигээ ажиллах-4% -	- Сайн ажиллавал Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж магадгүй-10% - Сайн ажиллаасай -5% - Хийсэн ажил нь харагддаггүй -1% - УИХ-ын ёс зүйд анхаарч ажиллаасай-1%
-	-	-	- МАН-ын хүн гэж бодсон тул итгэх итгэл унасан-23%	- Онгироо-4% - Гэмт хэрэгтэн гэж хардаг-3%	- Өөрийнхөө эрх ашгийн төлөө явдаг хүн -3% -
Намын дарга болоход тохиромжгүй-17%	*Нүүрсний хулгайтай холбоотой, ашиг сонирхлын зөрчилтэй тул намын дарга болох нь тохиромжгүй -9%*	*Намын дарга байхад тохиромжгүй-3%*			
Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-43%	*Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-37%*	*Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-45%*	*Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-41%*	*Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-47%*	*Хэлж мэдэхгүй, хүлээлт байхгүй-80%*

БҮЛЭГ ГУРАВ. 2027 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТААМАГЛАЛ

Судалгаанд оролцогчдоос 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон намаас хэн хэн нэр дэвшинэ гэж бодож байгааг тодруулахад 124 хүнээс давхардсан тоогоор 90 хариулт ирсэн нь 72.5%-ийн хариулт байна. Дээрх оролцогчид нийт 24 хүнийг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэж таамагласан. Оролцогчдын үзэж байгаагаар МАН-аас Г.Занданшатар, АН-аас О.Цогтгэрэл, ХҮН намаас Т.Доржханд, Бүгд Найрамдах намаас Б.Жаргалсайхан нэр дэвших магадлалтай гэжээ.

Гэвч УИХ-д суудалгүй БНН-аас нэр дэвших боломжгүй бөгөөд график 33-т нэр дурдагдсан зарим улс төрчид 2027 онд Ерөнхийлөгчид нэр дэвших насанд /50 нас/ хараахан хүрээгүй байх юм.

АН-аас О.Цогтгэрэл (12), Н.Алтанхуяг (9), Х.Тэмүүжин (6) нар нэр дэвших хамгийн өндөр магадлалтай гэж судалгаанд оролцогчид үзсэн бөгөөд шалтгааныг тодруулахад,

О.Цогтгэрэл шалгууртаа тэнцэж зөв төлөвлөгөө боловсруулбал хүчтэй өрсөлдөгч болох бөгөөд МАН-ын нэр дэвшигч тааруу хүн байвал ялалт байгуулж чадна гэсэн. Хувь хүн талаасаа карьер сайтай, амжилттай бизнес эрхлэгч ба намын даргаар итгэл хүлээсэн хүн.


Х.Тэмүүжин нэр хүнд сайтай бөгөөд АН хэрхэн ажиллахаас хамаарч ялалт байгуулах эсэх нь шалтгаална гэсэн.

График 33. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон намаас хэн хэн нэр дэвшинэ гэж бодож байгаа талаарх таамаглал /Давтамжаар/



2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар ялалт байгуулж чадах эсэхийг судалгаанд оролцогчдоос тодруулахад 124 оролцогчоос нийт 48 хүн буюу судалгаанд оролцогчдын 39% нь хариулсан бөгөөд бусад 76 хүн хариулаагүй эсвэл хэлж мэдэхгүй байна гэсэн. Хариулт өгсөн 48 хүнийг 100 гэж тооцвол тэдний 44% буюу 10 хүн тутмын 4 нь чадна гэсэн хариулт өгсөн байна. Харин 34% нь ялалт байгуулж чадахгүй, 22% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан байна.

График 34. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялалт байгуулж чадах эсэхэд иргэдийн таамаглал



Ерөнхий сайд Г.Занданшатарыг 2027 оны ерөнхийлөгчийн сонгуульд 44% буюу 10 хүн тутмын 4 нь ялалт байгуулж чадна гэж хариулсан. Оролцогчдоос ялалт байгуулж чадна гэсэн шалтгааныг тодруулж асуухад МАН-ын гишүүн учраас ялалт байгуулна 40%, Ерөнхий сайд байх хугацаандаа хэр зэрэг ажиллахаас хамаарна 30%, өрсөлдөх хүнээс нь хамаарна 27%, туршлагатай учраас ялалт байгуулна 3% гэсэн байдлаар хариултууд өгсөн байна.

График 35. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялна гэж таамагласан үндэслэл




Ерөнхий сайд Г.Занданшатарыг 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулж чадахгүй гэсэн шалтгааныг мөн тодруулахад хийж байгаа ажил нь харагддаггүй гэсэн хариулт хамгийн их буюу 27%-ын эзэлж байна. Мөн УИХ-ын сонгууль ялалт байгуулж чадаагүй, МАН олон жил эрх барьсан учраас ялалт байгуулж гэсэн хариултууд 20%-ийг эзэлж байна.

График 36. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшвэл ялагдана гэж таамагласан үндэслэл



2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аль намын нэр дэвшигч ялалт байгуулна гэж бодож байгаа талаар тодруулахад 44% буюу 10 хүн тутмын 4 нь МАН гэсэн хариулт өгсөн нь АН-аас 22%-аар илүү байна. Мөн МАН болон АН гэсэн хариулт 5%-ийг эзэлж байна.

График 37. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аль намаас нэр дэвшигч ялалт байгуулна гэж бодож байгаа талаарх үр дүн



СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хуралд суудалтай нам, эвслийн талаарх олон нийтийн байр суурийг тодорхойлох хэрэгцээ шаардлагыг үндэслэн Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захиалгаар Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль мэдээлэл цуглуулалтын ажлыг 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь 2024 оны сонгуулиар бүрдсэн, 126 гишүүнтэй шинэ УИХ-ыг олон нийтийн хүлээлтэд нийцэхгүй, өмнөх парламенттай харьцуулахад үр дүн муутай ажиллаж байна гэж үзсэн. Үүний шалтгааныг парламентын бүтэц томорсон ч зохион байгуулалт, сахилга хариуцлага сул, гишүүдийн оролцоо хангалтгүй, дотоод зөрчил их, хувийн ашиг сонирхол давамгайлж буйтай холбон тайлбарласан.

Нөгөө талаас холимог тогтолцоогоор сонгууль явагдсанаар олон намын төлөөлөл УИХ-д орж ирсэн нь олон ургалч байр суурь илэрхийлэгдэх, хяналт шүүмж нэмэгдэх эерэг өөрчлөлт авчирсан гэж үнэлсэн.

Сонгуулийн үр дүнг тайлбарлахдаа МАН-ыг 100 жилийн түүхтэй, харьцангуй тогтвортой рейтинг, хийж хэрэгжүүлсэн ажлууд зэрэг нь үнэлэгдэн ялалт байгуулсан гэж үзсэн бол АН дотоод зохион байгуулалт, залуу боловсон хүчнээ нэмэгдүүлж, эв нэгдэл сайжирснаар өмнөх сонгуулиас ахиц гаргасан гэж дүгнэсэн. Харин ХҮН намыг мэдлэг боловсролтой, салбартаа нэр хүндтэй, харьцангуй цэвэр имижтэй нэр дэвшигчидтэй байсан нь дэмжлэг нэмэгдэхэд нөлөөлсөн гэж үзжээ.

УИХ-д суудалтай намуудын үйл ажиллагааг үнэлэхдээ эрх баригч намыг бусад намаас өндрөөр үнэлсэн ч бодит ахиц, шинэчлэл хангалттай харагдахгүй байна гэсэн байр суурь давамгайлсан. Харин бусад намуудын хувьд юу хийж, хэрхэн ажиллаж байгаа нь тодорхой бус, сөрөг хүчний үүргээ бүрэн гүйцэтгэж чадахгүй байна гэж олонх нь дүгнэсэн.

Иргэд парламентаас сонгуулийн амлалтаа биелүүлж, амьжиргаанд бодит нөлөө үзүүлэх бодлого хэрэгжүүлэхийг нэн тэргүүнд хүлээж байна. Үүнд цалин, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн зөв бодлого баримтлах, авлига, хулгайтай бодитоор тэмцэх шаардлагыг онцолсон. Үүний тулд УИХ дотоод зөрчил багатай, ёс зүйтэй, хамтын ажиллагаатай ажиллах ёстой гэж үзсэн.

Эрх баригч МАН-аас эдийн засаг, төсөв, томоохон төслүүдийн хэрэгжилтэд анхааран илүү тодорхой, хариуцлагатай ажиллах, нийгмийн тулгамдсан асуудлуудын шийдлийг ил тод тайлагнаж байхыг хүссэн байна. Харин сөрөг хүчний намуудаас бодит хяналт шүүмж хийж, хоёр том намын дунд тэнцвэр барих гуравдагч хүчин байх чиг үүргээ илүү тодорхой хэрэгжүүлэхийг хүсэж байна.

Намууд болон УИХ-ын гишүүд албан тушаал, эрх мэдлийн маргаанд анхаарах бус, иргэдийн амьдралд шууд нөлөөлөх асуудлуудыг хамтран шийдвэрлэх шаардлагатай гэж дийлэнх оролцогчид үзсэн. Ахмад, туршлагатай гишүүдийн мэдлэгийг ашиглахын зэрэгцээ залуу гишүүдийг бодлого тодорхойлоход идэвхтэй оролцуулах, залууст илүү боломж олгох хэрэгтэй гэсэн.

Гишүүн бүр намын харьяаллаас үл хамааран ард түмний төлөөлөгчийнхөө хувьд сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтад туссан иргэдийн эрх ашигт нийцсэн асуудлыг нэн тэргүүнд тавьж ажиллах ёстой гэсэн байр суурь давамгайлсан.

Иргэд УИХ, Засгийн газраас амьжиргаанд шууд нөлөөлөх бодлого хэрэгжүүлж, үндэсний үйлдвэрлэл болон түүхий эд боловсруулах салбарыг дэмжих, хөдөө орон нутагт чиглэсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх, инфляцыг тогтвортой барих, ажлын байр, цалин, тэтгэврийн асуудлыг шийдвэрлэх, экспорт импортыг тэлэхийн зэрэгцээ төсвийн үр ашиггүй зардлыг танаж, байгалийн баялгийн ашиглалт, хуваарилалтад илүү шударга, хатуу хяналт тогтоохыг чухалчилж байна.

Намын удирдлагууд болон улс төрийн манлайллын талаар оролцогчдын дунд тодорхой хүлээлтээс илүүтэй эргэлзээ, тодорхойгүй байдал давамгайлж байгаа нь улс төрийн итгэл сул байгааг илтгэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад иргэд улс төрийн тогтвортой байдал, эв нэгдэл, хариуцлага, бодит үр дүнг хамгийн ихээр хүсэж байгаа бөгөөд амьдралд ойр, ойлгомжтой, хэмжигдэхүйц бодлогын хэрэгжилт нь олон нийтийн итгэлийг сэргээх гол хүчин зүйл гэж үзэж байна.

Өмнөх Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрын үйл ажиллагааг ерөнхийд нь боломжийн гэж үнэлсэн ч бодит үр дүн, иргэдийн амьдралд мэдрэгдэх өөрчлөлт хангалтгүй, төрийн бүтэц данхайсан, зардал өндөр, хяналт сул байсан гэж шүүмжилсэн. Харин одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газрыг дүгнэхэд эрт гэж үзэхийн зэрэгцээ туршлагатай удирдлагатай тул хүлээлт өндөр байгаа ч бодит үр дүн харагдаагүй байгааг онцолсон.

МАН-ыг бусад намаас харьцангуй өндөр үнэлсэн ч бодит өөрчлөлт, шинэчлэл харагдахгүй, олон жил эрх барьсан намын хувьд хариуцлагаа бүрэн ухамсарлахгүй байна гэж үзсэн. Намын удирдлагын түвшинд дотоод зөрчил хүчтэй байгаа нь Засгийн газар болон УИХ-ыг ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэжээ.

МАН-ын даргын сунгаанд өрсөлдөж буй Г.Занданшатарыг Д.Амарбаясгалангаас туршлагатай, хариуцлагатай, илүү тогтвортой удирдагч байж чадна гэж үзэх байр суурь ажиглагдсан. Олонх оролцогчид түүнийг намын дарга бөгөөд Ерөнхий сайдын хувьд бодлогын залгамж чанарыг хадгалж, дотоод зөрчлийг намжаах чадвартай гэж харж байна. Гэсэн ч бодит үр дүн богино хугацаанд харагдахгүй бол дэмжлэг хурдан сулрах эрсдэлтэй гэж үзсэн.

Д.Амарбаясгаланг ёс зүйтэй, хариуцлагатай улс төрч гэж үнэлэх хандлага байна. Түүнийг намын дарга болбол илүү сайн ажиллах хүлээлт байгаа ч нэр холбогдсон нүүрсний хэргээс болж иргэдэд эргэлзээ үүссэн байна.

АН-ын үйл ажиллагааг сөрөг хүчний хувьд хангалтгүй гэж дийлэнх оролцогчид үнэлсэн. Нам дотооддоо харьцангуй шинэчлэгдсэн ч УИХ дахь нөлөө, бодлогын тодорхой байр суурь сул тул иргэдийн итгэлийг бүрэн сэргээж чадаагүй байна.

АН-ын дарга О.Цогтгэрэлээс залуусыг түшиглэсэн, бодлогын шинэчлэл хийж, жинхэнэ сөрөг хүчний үүргээ гүйцэтгэхийг иргэд хүлээж байна. Түүнийг хувийн карьер, бизнесийн туршлагатай, зөв баг бүрдүүлж чадвал цаашид улс төрийн рейтинг нэмэгдэх

боломжтой гэж үзсэн ч намын дотоод нөлөөлөл, бодлогын тогтвортой байдал нь шийдвэрлэх хүчин зүйл гэж харж байна.

ХҮН намыг гуравдагч хүчин болж төлөвших боломжтой ч МАН-тай хэт ойр харагдаж байгаа нь итгэл сулруулах шалтгаан болж байна гэж олонх оролцогчид дүгнэсэн. Намын дарга Т.Доржханд мэргэжлийн, боловсролтой улс төрч гэж анх үнэлэгдэж байсан ч сүүлийн жилүүдэд иргэдийн хүлээлт унасан байна.

Үндэсний Эвслийн дарга Н.Номтойбаярыг идэвхтэй, нөөц бололцоотой улс төрч гэж харж байгаа ч хувь хүний имиж, ёс зүйн маргаан нь олон нийтийн дэмжлэгийг хязгаарлаж байна.

ИЗНН-ын дарга Б.Батбаатарын хувьд улс төрийн орон зайд харагдах байдал сул, хийсэн ажил нь олон нийтэд тодорхой бус байгаа нь намын нөлөөллийг хязгаарлаж байна гэж үзжээ.

Ерөнхийд нь дүгнэхэд, судалгаанд оролцогчдын дийлэнх нь намын дарга нараас тодорхой хүлээлтгүй эсвэл эргэлзээтэй байгаа нь Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудад итгэх итгэл сул байгааг илтгэж байна.

Судалгааны үр дүнгээс харахад 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас нэр дэвшигч ялалт байгуулах магадлал харьцангуй өндөр гэж олонх оролцогчид үзэж байна. Үүний гол шалтгаан нь намын зохион байгуулалт, санхүү, улс төрийн нөөц, олон жилийн эрх барьсан туршлагатай холбоотой.

МАН-аас Г.Занданшатар нэр дэвшвэл ялалт байгуулах боломж бусад өрсөлдөгчөөсөө илүү гэж үзэх хандлага байна. Гэхдээ энэ нь түүний Ерөнхий сайдын хувиар 2025–2027 онд хэр бодит үр дүн гаргахаас шууд хамаарна гэсэн тодорхой нөхцөлтэй дүгнэлт юм. Хэрэв бодит өөрчлөлт харагдахгүй бол дэмжлэг хурдан суларна гэдгийг оролцогчид онцолсон.

АН-аас О.Цогтгэрэл, Н.Алтанхуяг, Х.Тэмүүжин нарыг боломжит нэр дэвшигчдээр нэрлэж байгаа ч АН дотооддоо нэгдэж, хүчтэй бодлогын платформ гаргаж чадсан тохиолдолд л бодит өрсөлдөгч болж чадна гэж дүгнэжээ. Ялангуяа О.Цогтгэрэлийг шинэ үеийн төлөөлөл, зөв стратеги баривал МАН-ын нэр дэвшигчтэй өрсөлдөх боломжтой гэж харж байна.

ХҮН намаас Т.Доржханд яригдаж байгаа ч одоогийн байдлаар ялалт байгуулах бодит магадлал багатай, харин улс төрийн орон зайд нөлөөлөх, санал хуваах хүчин зүйл болно гэж олонх нь үзсэн.

Ерөнхий дүгнэлтээр, 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн ялалт нь намын харьяаллаас гадна нэр дэвшигчийн бодит ажил, олон нийтийн итгэлийг сэргээж чадсан эсэхээс шууд хамаарна.

НОМ ЗҮЙ

Монгол Улсын Хууль:

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль (2019 оны нэмэлт, өөрчлөлттэй).* Улаанбаатар:: Төрийн мэдээлэл. Retrieved from Монгол Улсын Үндсэн хууль (2019 оны нэмэлт, өөрчлөлттэй).

Монгол хэлээр:

Сонгуулийн ерөнхий хороо. (2024). *2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүн, суудлын хуваарилалт.* Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2024). *Улсын Их Хурлын бүрэлдэхүүн, намын бүлгүүдийн мэдээлэл.* Улаанбаатар.

Англи хэлээр:

Kitzinger, J. (1995). *Qualitative research: Introducing focus groups.* BMJ 311(7000), 299–302.

Morgan, D. L. (1997). *Focus Groups as Qualitative Research.* Sage Publications.

Pew Research Center. (2025). *Satisfaction with the way democracy is working In Spring 2025 Global Attitudes Survey*. Retrieved from https://www.pewresearch.org/topic/international-affairs/

Хавсралт 1

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛОН УЛСЫН ИХ ХУРАЛД СУУДАЛТАЙ 5 НАМ, ЭВСЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН БАЙР СУУРИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА”-НЫ ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТ

Ярилцлагын шаардлага

Судалгааны объект: 18-аас дээш насны, тухайн орон нутагт амьдардаг иргэн

№	Насны бүлэг	Нийт оролцогч	Эрэгтэй	Эмэгтэй
1	18-24 нас	2	1	1
2	25-29 нас	2	1	1
3	30-39 нас	2	1	1
4	40-49 нас	2	1	1
5	50-аас дээш	2	1	1
Нийт		**10**	**5**	**5**

Хугацаа: Ярилцлага ойролцоогоор 90-120 минут үргэлжилнэ.

Ашиглах тоног төхөөрөмж: Таблет, диктафон, гар утас

Оролцогчийн тоо: 10

Удирдамжийн хэлбэр: Хагас бүтэцлэгдсэн

Танилцуулга

Сайн байна уу? Бидний зохион байгуулж буй энэхүү ярилцлагын урилгыг хүлээн авч, өнөөдөр цаг гарган ярилцаж байгаа Танд баярлалаа. Намайг ..... гэдэг. “.....ийн .....-аар ажилладаг. Өнөөдөр би ярилцлагын чиглүүлэгчээр ажиллана.

Зорилго: Өнөөдрийн Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хуралд суудалтай 5 нам, эвслийн талаарх олон нийтийн байр суурийг тодорхойлох зорилгоор тус судалгааг хийж байна. Та тус судалгаанд оролцсоноор УИХ-ын үйл ажиллагааг сайжруулахад улс төрийн намууд хэрхэн ажиллах шаардлагатай талаар санал бодлоо илэрхийлэх боломжтой юм.

Батламж: Ярилцлага ойролцоогоор 90-120 минут үргэлжлэх бөгөөд энд Таны ярьж буй зүйлийг зөв, бүрэн байдлаар судалгааны тайланд тусгах, мэдээллийг боловсруулахад ашиглах зорилгоор аудио дуу хураагуур ажиллуулна. Дуу хураагуур дээрх бичлэгийг зөвхөн мэдээлэл боловсруулах, баримт бичиг боловсруулах зорилгоор ашигласны дараа шууд устгах болно. Бид Таны нууцыг Монгол Улсын Хувийн нууцын тухай хуульд заасны дагуу чандлан хадгалах болно.

Дүрэм: Би Таныг зөв, буруу гэж шүүхгүй учир Та санаа зоволгүйгээр чөлөөтэй ярилцаарай. Бидний ярилцлага аль болох чөлөөтэй, ямар нэгэн саадгүй байх үүднээс дараах дүрмийг баримтална.

- Ярилцлага үргэлжлэх хугацаанд Та утасныхаа дууг хаах, эсвэл түр унтраагаарай. Танд яаралтай дуудлага ирсэн тохиолдолд чиглүүлэгчээс зөвшөөрөл авахгүйгээр чимээгүй өрөөнөөс гарч ярьж болно.

- Мөн бусдыгаа хүндэтгэж нэг хүн ярьж дууссан тохиолдолд дараагийн хүн ярих хэлбэрээр ярилцлага үргэлжилнэ.
- Бүх оролцогчийн ярьж буй зүйл бидэнд үнэ цэнтэй тул Та бусад оролцогчийн ярьж буйтай санал нийлэхгүй тохиолдолд хүндэтгэлтэй хандахыг хичээгээрэй.
- Ярилцлагад оролцогчийн хүндэтгэж, ярилцахад хялбар байх үүднээс оролцогчид нэрээ бичиж, урдаа байршуулна.
- Ярилцлагад оролцогчоор Хавсралт-1 дэх асуулгыг бөглүүлнэ.

Ярилцлагын чиглүүлэх асуулт

№	АСУУЛТ	ЧИГЛЭЛ
1	• Өдрийн мэнд. Цаг заваа гаргаж ярилцлагад оролцож байгаад талархал илэрхийлье. Төр өөрийгөө танилцуулна уу. (Нэр, нас, харьяалал, ажил эрхлэлт, боловсрол). Та нэрээ хэлэхдээ заавал албан ёсны нэрээ хэлэх албагүй бөгөөд хэн гэж дуудуулахыг хүссэн нэрээрээ өөрийгөө танилцуулаарай.	**Ерөнхий Мэдээлэл**
2	• Сайхан зуншсан уу, сайхан намаржиж байна уу? • Орон нутагтаа амьдраад хэр удаж байна вэ?	**Халааltын асуултууд**
Нэг. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
3	• 2024 оны УИХ-ын сонгуулиар МАН, АН, ХҮН нам, Үндэсний эсвэл, Иргэний Зориг нам УИХ-д суудал авсан. Сонгуулийн үр дүнд бүрдсэн УИХ таны хүлээлтэд нийцэж байна уу? Тийм бол яагаад, Үгүй бол яагаад? • 2024 оны сонгуулиар МАН олонх болж, ялалт байгуулсан. Ялалтын шалтгааныг Та юу гэж харж байна вэ? • 2024 оны сонгуулиар АН хүчтэй сөрөг хүчин болохуйц хэмжээний суудал авч чадсан. Тус үр дүнд хүрч чадсан шалтгаан нь юу вэ? • ХҮН нам УИХ-д 8 суудал авч, өмнөх сонгуулиудтай харьцуулахад гишүүдийн тоогоо нэмж чадсан. Тус үр дүнд хүрч чадсан шалтгааныг юу гэж бодож байна вэ? • Та 2024 оны УИХ-ын сонгуулиар хэн гэдэг нэр дэвшигчид яагаад саналаа өгсөн бэ? Таны хүлээлтэд хэр зэрэг нийцэж байна вэ? ***(Санал өгсөн хүний нэрийг нэрлүүлж, тус бүрээр сонгосон шалтгаан, хүлээлтэд нь нийцсэн эсэх талаар асууна)***	**2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүн**
4	• 2024 оны сонгуулиар бүрдсэн 126 гишүүнтэй парламент өмнөх 76 гишүүнтэй парламенттай харьцуулахад хэр зэрэг ажиллаж байна вэ? • УИХ-д суудал бүхий 5 нам, эвсэл (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) хэр зэрэг ажиллаж байна гэж Та бодож байна вэ? - МАН хэр зэрэг ажиллаж байна вэ? - АН хэр зэрэг ажиллаж байна вэ? - ХҮН нам хэр зэрэг ажиллаж байна вэ? - Үндэсний эвсэл хэр зэрэг ажиллаж байна вэ? - ИЗНН хэр зэрэг ажиллаж байна вэ? • Та УИХ-д суудал бүхий МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН-уудаас ямар хүлээлттэй байна вэ? ***(Нам тус бүрээр асууна)*** - Та МАН-аас ямар хүлээлттэй байна вэ? - Та АН-аас ямар хүлээлттэй байна вэ? - Та ХҮН намаас ямар хүлээлттэй байна вэ? - Та Үндэсний эвслээс ямар хүлээлттэй байна вэ? - Та ИЗНН-аас ямар хүлээлттэй байна вэ?	**УИХ-д суудал бүхий улс төрийн намуудын талаарх байр суурь**

	• Таны бодлоор одоогийн УИХ-ын үйл ажиллагааг сайжруулахын тулд УИХ-д суудал бүхий 5 нам (МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, ИЗНН) хэрхэн ажиллах хэрэгтэй вэ?	
5	• Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар өнгөрсөн хугацаанд хэр зэрэг ажилласан гэж Та бодож байна вэ? Сайн бол яагаад, муу бол яагаад? • Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газар хэр зэрэг ажиллаж байна вэ? Сайн бол яагаад, үгүй бол яагаад? • Одоогийн Ерөнхий сайд Г.Занданшатарын Засгийн газраас ямар хүлээлттэй байна вэ?	**Засгийн газрын үйл ажиллагаа**
Хоёр. УЛС ТӨРИЙН НАМ		
6	• МАН-ын намын даргын сунгаанд Ерөнхий сайд Г.Занданшатар, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нар өрсөлдөхөөр байна. Та хэнийг нь МАН-ын дарга байхад тохирно гэж харж байна вэ? - Ерөнхий сайд Г.Занданшатар МАН-ын дарга болбол ямар хүлээлттэй байна вэ? - УИХ-ын дарга Д.Амарбаясгалан МАН-ын дарга болбол ямар хүлээлттэй байна вэ? • Саяхан АН-ын Үндэсний Бодлогын Хороо хуралдаж, АН-ын даргаар О.Цогтгэрэлийг сонгосон. Түүнийг хэрхэн ажиллана гэсэн хүлээлттэй байна вэ? • ХҮН намын дарга Т.Доржханд хэрхэн ажиллана гэсэн хүлээлттэй байна вэ? • Үндэсний эвслийн дарга Н.Номтойбаярыг хэрхэн ажиллана гэсэн хүлээлттэй байна вэ? • ИЗНН-ын дарга Б.Баярбаатарыг ирээдүйд хэрхэн ажиллана гэж Та харж байна вэ?	**Улс төрийн намын тухайд**
Гурав. 2027 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТААМАГЛАЛ		
7	***Монгол Улсын Үндсэн хуульд "Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 6 жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж заасан байдаг. Тиймээс 50 нас хүрээгүй УИХ-ын дарга Д.Амарбаягалан, Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнэ гэх мэт залуучуудын төлөөллийн нэрийг дараах асуултад хариултаар авахгүй.*** • 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН, АН, ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний Зориг намаас хэн хэн нэр дэвшинэ гэж Та бодож байна вэ? • 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшинэ гэсэн яриа байна. Тэр ялалт байгуулж чадах болов уу? Чадах бол яагаад, чадахгүй бол яагаад? • 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас хэн нэр дэвших хамгийн магадлалтай вэ? Нэрлэсэн хүн нь ялалт байгуулж чадах болов уу? Чадах бол яагаад, чадахгүй бол яагаад? ***(О.Цогтгэрэл, Х.Тэмүүжин нарын нэр нэрлэгдвэл ялалт байгуулж чадах эсэх, үндэслэлийг дэлгэрэнгүй асууж яриулна)*** • 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуульд аль намаас нэр дэвшигч ялалт байгуулна гэж Та бодож байна вэ? Яагаад?	**2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх байр суурь**